



## **РОБЕРТ Х.Н. ХОГИЙН ГЭР БҮЛИЙН САНГААС БУДДЫН ШАШИН СУДЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТЭТГЭЛЭГ ОЛГОХ 2024-25 ОНЫ ОЛОН УЛСЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ**

Роберт Н. Хогийн гэр бүлийн сангийн буддын шашин судлалын хөтөлбөрийн 2024-25 оны сонгон шалгаруулалтад оролцохыг Судалгааны Нийгэмлэгүүдийн Америкийн Зөвлөл (СНАЗ) урьж байна. СНАЗ тус **Сантай** хамтран эрдэмтэн судлаачдын дунд, мөн нийгэм дэх буддын шашны сэтгэлгээний ойлголт, тайлбарыг нэмэгдүүлж өргөжүүлэх, буддын шашин судлаачид олон улсад хамтран ажиллахыг бэхжүүлэх, буддын шашны өв уламжлалтай холбоотой шинэ мэдлэг, судалгааг сурталчлан таниулах ажлыг дэмжих зорилгоор тэтгэлэг олгодог.

Энэ бол олон улсын сонгон шалгаруулалт юм. Буддын шашны өв уламжлалын аливаа чиглэлийг судалдаг дэлхийн аль ч орны бүх судлаач, эрдэмтэд оролцох өргөдлөө гаргах боломжтой. Санал болгож буй ажлын байршил эсвэл өргөдөл гаргагчийн иргэний харьяалалд тавих ямар ч хориг хязгаарлалт байхгүй.

**СНАЗ Азийн их дээд сургууль, сүм хийдийн байгууллагуудтай холбоотой эрдэмтэн, судлаачид өргөдөл гаргахыг хөхиүлэн дэмждэг.**

Өргөдлийг англи хэлээр гаргах ёстой боловч судалгааны эцсийн бүтээгдэхүүн ямар ч хэлээр байж болно. Судалгааны ажлыг **хүмүүнлэгийн болон тайлбарлах нийгмийн ухааны** салбарт хийх ёстой.

**Дараах сонгон шалгаруулалтын эцсийн хугацаа Зүүн мужийн стандарт цагаар 2024 оны 12-р сарын 3-ны 21:00 цаг байна.**

- Буддын шашин судлалын диссертацийн тэтгэлэг
- Буддын шашин судлалын чиглэлээр олгох гарааны судалгааны тэтгэлэг
- Буддын шашин судлалын чиглэлээр олгох орчуулгын тэтгэлэг

**Дараах сонгон шалгаруулалтын эцсийн хугацаа Зүүн мужийн стандарт цагаар 2025 оны 1-р сарын 23-ны 21:00 цаг байна.**

- Буддын шашны олон нийтийн судлаач
- Буддын шашин судлалын чиглэлээр олгох профессорын шинэ тэтгэлэг

**Хөтөлбөр, тэтгэлгийн талаар ерөнхий мэдээллийг доороос авна уу.**

<https://www.acls.org/programs/robert-h-n-ho-family-foundation-in-buddhist-studies/>

**Байнга асуудаг асуултуудыг доороос үзнэ үү.**

<https://www.acls.org/faqs/faq-the-robert-h-n-ho-family-foundation-program-in-buddhist-studies/>